

АГУУЛГА

НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	4
“Сэрвэн” нэртэй хайлуур жоншны орд ашиглалтын товч мэдээлэл	4
Ордын нөөц.	4
Ашиглалтын систем	4
Уулын ажлын горим.....	4
Төслийн дэд бүтэц.....	5
Усан хангамж.	5
Цахилгаан хангамж.	5
Зам харилцаа.	5
Уурхайн барилга, байгууламж	5
ХОЁР. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	5
2.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	6
2.1.2. Хөрс хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	13
2.2. Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө	29
Техникийн нөхөн сэргээлт	31
Биологийн нөхөн сэргээлт.....	32
2.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	38
2.4. Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох төлөвлөгөө.....	39
2.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	39
2.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	39
2.7. Хог хаягдлын менежмент.....	44
2.8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	50
ГУРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	53
3.1. Хөрсний хяналт-шинжилгээний үр дүн	53
3.2. Усны хяналт-шинжилгээний үр дүн.	54
3.3. Агаарын чанарын хяналт-шинжилгээний үр дүн.....	55
ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОН НУТАГТ ТАЙЛАГНАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ.....	55
ХАВСРАЛТ МАТЕРИАЛ.....	57

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн товч мэдээлэл	4
Хүснэгт 2. Унд ахуйн хэрэглээнд ашиглах гүний худгийн солбицол.	5
Хүснэгт 3. Агаарын чанарт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	6
Хүснэгт 4- Хөрс, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	14
Хүснэгт 5. Хөрсний шинжилгээний үр дүн	21
Хүснэгт 6- Гадаргын болон газрын гүний усанд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	25
Хүснэгт 7- Ургамал ба амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ	27
Хүснэгт 8- Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилт	29
Хүснэгт 9- Нөхөн сэргээлт хийсэн талбайн координат	31
Хүснэгт 10- Нөхөн сэргээлтэд ашигласан ургамлын төрөл	33
Хүснэгт 11-Ашигласан бордооны мэдээлэл.....	34
Хүснэгт 12-Биологийн нөхөн сэргээлтийн ажилд ашигласан техник	34
Хүснэгт 13-Эвдрэл үүссэн талбайг ургамалжуулах хугацаа	35
Хүснэгт 14- Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	38
Хүснэгт 15- Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт	39
Хүснэгт 16- Хог хаягдлын менежментийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	44
Хүснэгт 17- Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	50
Хүснэгт 18. Хүнд металлын шинжилгээний үр дүн.....	54
Хүснэгт 19- Усны химийн завлан шинжилгээний үр дүн	54
Хүснэгт 20. Агаарын чанарын шинжилгээний үр дүн	55
Хүснэгт 21- 2025 БОМТ-ний Биелэлтийн ажилд шаардагдсан нийт зардал	56

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Агаарын чанарын хяналтыг цэгүүд	8
Зураг 2. Агаарын чанарын хэмжилтийг утга (PM 2.5 нарийн ширхэгт тоосонцорын дундаж агууламж, мкг/м ³)	9
Зураг 3. Сургалтанд хамрагдсан ажилчдын нэрс	10
Зураг 4. Сургалтын материалын хэсэг	11
Зураг 5. Уурхайд ашиглаж буй тоосноос хамгаалах баг.	12
Зураг 6. Ажлын хувцас хэрэгсэл худалдан авсан баримт.	12
Зураг 7. Маркшейдрийн хэмжилтийн үр дүн.....	14
Зураг 8. Сургалтанд хамрагдсан ажилчдын нэрс	16
Зураг 9. Сургалтын материалын хэсэг	17
Зураг 10. Уурхайн кемпээс урагш хөрсний отвацийн урд хэсэгт тарьсан улиас мод	18
Зураг 11. Нүхэн жорлонгын урд тарьсан модны зураг	18
Зураг 12. Тэсэлгээний агуулахын дэргэд тарьсан Улиас мод	19
зураг 13. Шимт хөрсийг овоолго үүсгэж хадгалсан ажлын зураг.	20
Зураг 14. Овоолго үүсгэсэн шимт хөрсийг нөхөн сэргээлтэд ашиглаж буй ажлын зураг ...	21
Зураг 15. Шинжилгээний бичиг.	22
Зураг 16. Зам засварын ажлын зураг	22
Зураг 17. Дотоод тээврийн зам тэмдэгжүүлсэн ажлын зураг	24

Зураг 20.....	24
Зураг 21. Тус ажлын хүрээнд ашиглалтын талбайгаас баруун хойш 7.8 км зайд орших Энгэр булгийг хашаална.	27
Зураг 22. Ариутгалын ажлын зураг	28
Зураг 23. Нөхөн сэргээлт хийсэн талбай хүлээлгэж өгөх тухай хүсэлт	30
зураг 24. Нөхөн сэргээлт хийсэн талбайн зураг	31
Зураг 25. Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн сансрын зураг, (google earth pro)	32
Зураг 26. Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайн сансрын зураг	32
Зураг 27. Уурхай дээр мод тарьсан ажлын зураг.....	37
Зураг 28.....	38
Зураг 29. Эмнэлгийн анхан тусламжын хайрцаг	41
Зураг 30. Уурхайн кемпийн гадна, харуулын байр, ШТС-ын дэргэд байрлуулсан галын сараа.	42
Зураг 31. Гэр кемпүүд болон гал тогоонд байруулсан галын хор	43
Зураг 32.....	48
Зураг 33.....	49
Зураг 35. 2025 оны газрын төлбөрийн мэдээлэл	51
Зураг 36. 2025 оны 01-р сараас 6-р сар хүртэл ашигласан усны төлбөрийн баримт	52
Зураг 37. ИНХ-аар уурхайн үйл ажиллагааг ард иргэдэд танилцуулсан ажлын зураг	56

НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төслийн зорилго: Сэрвэнгийн хайлуур жоншны ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны бүрэлдэхүүн хэсэгт учруулах сөрөг нөлөөг буруулах арга хэмжээг авч, илэрсэн зөрчлийг арилгах, холбогдох хууль журмын хэрэгжилтийг хангах, орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулах, ажилчдыг аюулгүй тав тухтай орчинд ажиллах нөхцөл бололцоогоор хангаж ажиллана.

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн товч мэдээлэл

<i>Төслийн нэр</i>	“Сэрвэн” нэртэй жоншны ордыг ашиглах төсөл
<i>Төсөл хэрэгжүүлэгч</i>	“Биг могул гранд” ХХК
<i>Улсын бүртгэлийн дугаар</i>	9011652061
<i>Регистрийн дугаар</i>	6191142
<i>ААН-ийн хаяг</i>	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо 45А байр, 302 тоот

“Сэрвэн” нэртэй хайлуур жоншны орд ашиглалтын товч мэдээлэл

Ордын нөөц.

Сэрвэн хайлуур жоншны ордод 2007 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлангаар бодитой (В) зэрэглэлээр 46.68%-ийн дундаж агуулгатай 370.3 мян.тн хүдрийн нөөц тогтоогдож Монгол улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.

Ашиглалтын систем

2024 оны батлагдсан Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу өмнөх хүдрийн биетийн гаршаас илээр олборлон, зарим хэсэгт буцаан дүүргэсэн хэсгийг далд уурхайн таазыг тодорхойлох, цэвэрлэх зорилгоор +1135 түвшин хүртэл ил аргаар автотээвэртэй, гадаад овоолготой, үлдсэн хэсгийг далд аргаар хүдэр хоршоолон нураах ашиглалтын системээр ашиглана гэж тусгасан.

Уулын ажлын горим

Ил уурхайн уулын ажил нь жилд 4-5 сард явагдана. Үйлдвэрлэлийн үндсэн процессууд нь тасралтгүй 7 хоног, өдөрт 1 ээлжээр 10 цагаар явагдана.

Далд уурхай нь жилийн турш тасралтгүй горимоор ажиллана. Ээлжийн үргэлжлэх хугацааг хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу гүний уурхайн ажилчдад 7 цагаар, газрын дээрх ажилчдад 8 цагаар явагдана.

2025 оны Уулын ажлын төлөвлөгөөнд тооцсоноор далд уурхайн жилд ажиллах бодит хугацаа **300** хоног байна.

2025 онд компанийн нөхцөл байдлаас шалтгаалан уурхай нь 2025 оны 01-р сарын 01-ээс 2025 оны 08-р сарын 30 хүртэл ашигт малтмал олборлох, тээвэрлэх үйл ажиллагаа явуулаагүй.

2025 оны 09-р сараас эхлэн гэрээт компани үйл ажиллагаа явуулж байна.

Үйл ажиллагаа түр зогссон тухай тодорхойлолтыг тайланд хавсралтаар оруулав.

Төслийн дэд бүтэц.

Усан хангамж. Унд ахуйн хэрэглээнд ашиглах усны хэрэгцээг төсөл хэрэгжих талбайд байрлах гүний худгаас, зам талбайн тоосжилт дарах болон нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн усалгаанд шаардлагатай усны хэрэгцээг уурхайн үйл ажиллагааны явцад шүүрэн орж ирэх шүүрлийн усаар хангана.

Усны төлбөрийг Хэрлэн голын сав газрын захиргаатай байгуулсан 2025 оны ус ашиглах гэрээнд зааснаар унд ахуйн худаг болон шүүрлийн ус шавхах хэсэгт суурилуулсан тоолуурын заалтын дагуу төлсөн бөгөөд гэрээний хэрэгжилтэд Батноров сумын ЗДТГ-аас хяналт тавин ажиллаж байна.

Хүснэгт 2. Унд ахуйн хэрэглээнд ашиглах гүний худгийн солбицол.

Д/д	Өргөрөг			Уртраг			Ундарга (л/с)
1.	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд	1.0
	47	42	34.20	111	35	23.90	

Цахилгаан хангамж.

Сэрвэн уурхай нь төвийн эрчим хүчнээс алс зайд оршдог тул уурхайн шаардлагатай эрчим хүчийг Дизель – Станц буюу дизель цахилгаан үүсгэврээр хангаж байна.

БНХАУ-д үйлдвэрлэсэн STF-650-1-4 маркын 630 кВт чадалтай 2 ширхэг дизель генератор сонгосон.

Зам харилцаа.

Зам харилцаа харьцангуй сайн хөгжсөн бүсэд байрлана. УБ-Хэнтий аймгийн төв, Хэнтий аймаг-Батноров сум хүртэл аспалтан замаар холбогдсон.

Батноров сумаас Сэрвэн уурхай хүртэл 25 км ердийн шороон замаар явдаг.

Уурхайн барилга, байгууламж

Уурхайн барилга ажилчдын гэр болон котенейрон сууц , гал тогоо болон ариун цэврийн барилга байгууламж, агуулах-засварын байр багтана.

ХОЁР. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хэнтий аймгийн Батноров суманд орших ашигт малтмалын MV-10434 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Сэрвэн нэртэй хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах” төслийн 2025 оны Байгаль орчны менежмент төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулахдаа БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежмент төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримталсан бөгөөд тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын биелэлтийн байдлыг нэг бүрчлэн тодорхойлж, шаардагдсан хөрөнгө зардлыг тооцсон.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийн хэсэгт хяналт шинжилгээний ажлын үр дүнг дэлгэрэнгүй хэлбэрээр тусгасан болно.

Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд түүний биелэлтийн тоон үзүүлэлтийг дараах хүснэгтэнд нэгтгэн илэрхийлэв.

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт хэрэгжиж буй “Сэрвэн хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн БОМТ-ний биелэлтийн тайлан-2025 он

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төрөл	Төлөвлөсөн ажлын тоо	Гүйцэтгэсэн ажлын тоо	Хийгдэж буй болон хойшлуулсан ажлын тоо
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	16	14	2
2.	Нөхөн сэргээлт, ногоон байгууламжтай холбоотой ажлын төлөвлөгөө	5	5	-
3.	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	2	2	-
4.	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	0	-	-
5.	Нүүлгэн шилжүүлэлт нөхөн олговор олгох ажлын төлөвлөгөө	0	0	-
6.	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	6	5	1
7.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	6	4	2
8.	Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө	4	4	-

2.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд нийт 16 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Нийт төлөвлөсөн ажлын биелэлт 16/14.

Хүснэгт 3. Агаарын чанарт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Д/д	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд тусгасан ажил	Арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлсэн ажил	Баримтжуулсан материал
1.	Уурхайд орж гарах машин, ачилт буулгалтын цаг хугацаа, хоорондын зайг тоосны сарнилттай уялдуулан оновчтой байлгах тооцоог хийж мөрдөж ажиллах	- Уурхайд орж гарах маршрутыг тодорхойлон боловсруулж батлагдсан замын маршрутаар тээвэрлэлт хийж байна. - Дараалал үүсгэхгүй байхаар техникийн хоорондын зайг 50 м байхаар тогтоож байгууллагын дотоод журамд тусгаж өгсөн. - Уурхай дотор хурдны хязгаар 40 км/ц байхаар тогтоосон. - 2025 оны 10-р сарын 09-ний өдрөөс эхлэн урхай дээр агаарын нарийн ширхэгт тоосонцор	Байгууллагын дотоод үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах журмын батлагдсан нүүр, Агаарын тоосжилтын хэмжилтийн ажлын үр дүн хавсаргав.

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт хэрэгжиж буй “Сэрвэн хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн БОМТ-ний биелэлтийн тайлан-2025 он

		(PM2.5) хэмжих гар багаж ашиглан уурхайн орчимд тоосжилт их үүсэх магадлалтай цэгүүдэд хэмжилт хийн хяналт тавьж ажилласан. Хэмжсэн үзүүлэлтийг (PM2.5) “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS4585:2016 стандартад заасан 24 цагийн дундаж агууламжтай харьцуулан хяналт тавин ажилласан.	
2.	Агаарын тоосжилтын хэмжилтийг тогтмол хийж бүртгэл хөтлөх агаарын чанарын стандартад заасан хүлцэх агууламжаас хэтэрсэн тохиолдолд шаардлагатай арга хэмжээг авах	2025 оны 10-р сарын 09-ний өдрөөс эхлэн урхай дээр агаарын нарийн ширхэгт тоосонцор (PM2.5) хэмжих гар багаж ашиглан тоосжилт их үүсэх дотоод тээврийн зам, засварын талбай, гал тогоо дотор буюу нийт 3 цэгт тогтмол хэмжилт хийсэн. Хэмжсэн үзүүлэлт нь (PM2.5) “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS4585:2016 стандартад заасан 24 цагийн дундаж агууламжаас хэтрээгүй байна.	Хэмжилтийн ажлын үр дүнг доор оруулав.
3.	Хүнд машин механизмын утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах, үзлэг шалгалтыг хийх засвар үйлчилгээг тогтмол хийх	Уурхайд ашиглагдаж буй нийт 5 техник (утгуурт ачигч – 1, экскаватор – 1, автосамосвал – 1, 5 тн-ын өөрөө буулгагч – 2)-ийн засвар үйлчилгээг уурхайд гэрээгээр үйл ажиллагаа явуулж буй компани бүрэн хариуцан ажиллаж байна.	-
4.	Уурхайн ажиллагсдад тоосноос хамгаалах хушуувч, амны маск, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах, сургалт явуулах	- Уурхайд үйл ажиллагаа явуулж буй гэрээт компани нь ажилчиддаа нарийн ширхэгт тоосонцроос хамгаалах маскаар ханган ажиллаж байна. - Уурхайн ажилчдын эрүүл мэндийг дэмжих зорилгоор Витамин С, Цэнэг зэрэг	Тоосноос хамгаалах маск, хэрэгслийн зураг, хамгаалах хэрэгсэл худалдан авсан баримт, Хүнсний нэмэлт бүтээгдэхүүн худалдан авсан баримт, Сургалтанд хамрагдсан ажилчдын гарын үсэг хавсаргав.

		бүтээгдэхүүнийг ажилчдад нэмэлтээр тараасан. - 2025 оны 04-р сарын 29-ний өдөр “Агаарын чанарын индексийн тухай ойлголт, тоосжилтоос өөрсдийн эрүүл мэндийг хэрхэн хамгаалах тухай” болон “Хөрсний бохирол” гэсэн 2 сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулсан. Сургалтанд тухайн үед уурхайн кемп дээр ажиллаж байсан нийт 27 ажилтан хамрагдсан.	
5.	Уурхайн орчинд тоосжилтын хэмжилт (PM2.5, 10)	Уурхайн UNI-T A25D маркийн агаарын чанар шалгагч гар багаж ашиглан PM2.5 нарийн ширхэгт тоосонцорын хэмжилтийг тогтмол хийж байна.	Хэмжилтийн үр дүн болон хэмжилтийн ажлын зураг хавсаргав.

Орчны тоосжилтыг тогтмол хэмжисэн ажлын үр дүн




Зураг 1. Агаарын чанарын хяналтыг цэгүүд

Ажлын хүрээнд UNI-T A25 маркийн гар багаж ашиглан өдөрт тогтсон цагт өглөө, өдөр, орой 3 удаа хэмжилт хийн, хэмжилтийн дундаж утгыг “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS4585:2016 стандартад заасан 24 цагийн дундаж агууламжтай харьцуулан хяналтын ажлыг гүйцэтгэсэн.

Доорх графикт 2025 оны 10-р сарын 09-ний өдрөөс 10-р сарын 31-ний өдөр хүртэлх тоосжилтын утгыг долоо хоногоор дундажлан стандартад заасан хэмжээтэй харьцуулж харуулав.

Агаарын чанарын хэмжилт хийсэн хугацаа: 2025 оны 10-р сарын 09-өөс 10-р сарын 31-ний өдөр



Зураг 2. Агаарын чанарын хэмжилтийг утга (PM 2.5 нарийн ширхэгт тоосонцорын дундаж агууламж, мкг/м³)

Агаарын чанарын хэмжилтэд ашиглаж буй багаж:



Үзүүлэлт

Тайлбар

- | | |
|---------------------------|---|
| 1. Хэмжих үзүүлэлт | PM2.5, Температур (°C/°F),
Харьцангуй чийгшил (%) |
| 2. PM2.5 хэмжилтийн хүрээ | 0 – 300 µg/m³ |
| 3. PM2.5 нарийвчлал | ± 10 µg/m³ (бага утгууд дээр) /
± 10% (өндөр утга) |
| 4. Дэлгэц | Том LCD, гэрэлтүүлэгтэй |
| 5. Тэжээл | USB цэнэглэдэг баттерей /
тасралтгүй ажиллана |
| 6. Өнгөний индикаци | Смайл дүрсээр агаарын чанарыг
үнэлэх |
| 7. Чийгшил хэмжилт | 0 – 99%RH (±5% нарийвчлал) |
| 8. Температур | –10°C – +50°C |

Ашиглах орчин


- Дотор болон гадаа орчинд, мөн тээврийн хэрэгсэлд ашиглаж болно.
- Өндөрлөг: < 2000 м
- Тоосонцрын хэмжээ 0-500 µg/m³ хүртэл

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт хэрэгжиж буй “Сэрвэн хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн БОМТ-ний биелэлтийн тайлан-2025 он

- Ажлын температур: $-10^{\circ}\text{C} \sim +50^{\circ}\text{C}$
- Ажлын чийгшил: $0-99\% \text{ RH}$
- Хадгалах температур: $-20^{\circ}\text{C} \sim +60^{\circ}\text{C}$

UNI-T A25 маркийн тоосжилт хэмжих багаж нь CE/UKCA сертификаттай баталгаажсан багаж байна.

2025 оны 04-р сарын 29-ний өдөр зохион байгуулсан “Агаарын чанарын индексийн тухай ойлголт, тоосжилтоос өөрсдийн эрүүл мэндийг хэрхэн хамгаалах тухай” болон “Хөрсний бохирол” гэсэн 2 сэдвийн хүрээнд сургалтанд хамрагдсан ажилчдын нэрс.



Зураг 3. Сургалтанд хамрагдсан ажилчдын нэрс

Сургалтын материалын хэсэг.

ХОЁРДУГААР ХЭСЭГ

АЖЛЫН ОРЧИНД ТООСЖИЛТООС ХАМГААЛАХ НЭГ БҮРИЙН ХУВЦАС ХЭРЭГСЭЛ

Activate Window

АМЬСГАЛЫН ЭРХТЭН ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛ

- Үйлдвэрлэлийн тоос, химийн бодис, утаа, угаар болон агаарын найрлага дахь хорт хийн бүтээгдэхүүнээс хамгаалах зорилгоор амьсгал хамгаалах хэрэгсэл болох нэг удаагийн амны хаалт, хошуувчтай амьсгалын баг, тусгай хий соруулсан амьсгалын хэрэгсэл, амьсгалын аппарат зэргийг хэрэглэнэ.
- Агаарт тархсан тоосонцор, утаа тортог, хорт утаа, хий, уур манан ба ууршилттай орчинд ажиллагсад тухайн нөхцөлд тохирсон зориулалтын амьсгалын эрхтнийг хамгаалах хэрэгслийг заавал хэрэглэнэ.
- Амьсгал хамгаалах хэрэгслийн шүүлтүүрийг тухайн агаарын бохирдолд тохируулан хэрэглэнэ.



НЭГ БҮРИЙН ХАМГААЛАХ ХЭРЭГСЛИЙГ ИЖ БҮРЭН ХЭРЭГЛЭХ:



Зураг 4. Сургалтын материалын хэсэг.

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт хэрэгжиж буй “Сэрвэн хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн БОМТ-ний биелэлтийн тайлан-2025 он

Уурхайд ашиглаж буй тоосноос хамгаалах хэрэгсэл.

Тоосноос хамгаалах битүү маск



Зураг 5. Уурхайд ашиглаж буй тоосноос хамгаалах баг.

НХМаягт БМ-3

Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 347 тоот тушаалын кассарт

ЗАРЛАГЫН БАРИМТ № 7129825

(Байгууллагын нэр)

(Худалдан авагчийн нэр)

Регистрийн №

Регистрийн №

20.08 оны 08 сарын 09 өдөр

(тээвэрлэгчийн хаяг, албан тушаал, нэр)

№	Материал үнэт зүйлийн нэр, зэрэг, дугаар	Код	Хэм-жих нэгж	Худалдах	
				Тоо	Нийт дүн
1	А 4x6м	41	15	8000	150000
2					
3	1x1м	41	15	15000	250000
4					
5	10м	41	15	5000	100000
6					
7	1x2м	41	15	4000	60000
8					
9	10м	41	10	2500	40000
10	10м	41	10	800	20000
11	10м	41	15	9000	60000
12					
13					
14					
15					
16					
17					
18					
19					
20					

Тэмдэгт Хүлээн-авачиг

Шалгасан нягтлан бодогч:

НХМаягт БМ-3

Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 347 тоот тушаалын кассарт

ЗАРЛАГЫН БАРИМТ № 7129825

(Байгууллагын нэр)

(Худалдан авагчийн нэр)

Регистрийн №

Регистрийн №

20.08 оны 08 сарын 09 өдөр

(тээвэрлэгчийн хаяг, албан тушаал, нэр)

№	Материал үнэт зүйлийн нэр, зэрэг, дугаар	Код	Хэм-жих нэгж	Худалдах	
				Тоо	Нийт дүн
1	А 4x6м	41	15	8000	150000
2					
3	1x1м	41	15	15000	250000
4					
5	10м	41	15	5000	100000
6					
7	1x2м	41	15	4000	60000
8					
9					
10					
11					
12					
13					
14					
15					
16					
17					
18					
19					
20					

Тэмдэгт Хүлээн-авачиг

Шалгасан нягтлан бодогч:

Зураг 6. Ажлын хувцас хэрэгсэл худалдан авсан баримт.

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт хэрэгжиж буй “Сэрвэн хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн БОМТ-ний биелэлтийн тайлан-2025 он

Хүйтний улирал эхлэх үед уурхайн ажилчдыг дараах дархлаа дэмжих бүтээгдэхүүнүүдээр хангав.




2.1.2. Хөрс хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

2025 онд батлагдсан уулын ажлын төлөвлөгөөгөөр уулын ажил нь илээр 4-5 сард, далд аргаар тасралтгүй явагдахаар төлөвлөж, тус онд нийт 8,330 м³ хөрс хуулалтын ажил хийхээр төлөвлөсөн байсан ч компани нь эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан 2025 оны 01-р сарын 01-ний өдрөөс 08-р сарын 30-ний өдөр хүртэл уулын ажил түр зогсож, 2025 оны 09-р сараас эхлэн гэрээт компани ажиллаж эхлэсэн. Иймд 2025 онд төлөвлөгөөнд тусгасан хэмжээгээр хөрс хуулалтын ажил хийгдээгүй.

2024 оны үйл ажиллагаагаар олборлолт явуулах талбайн шимт хөрсийг хуулж овоолго үүсгэн хадгаласан.

2025 оны 02-р сарын 22-ний маркшейдрийн хэмжилтээр нийт овоолго үүсгэсэн шимт хөрсний хэмжээ 14,283 м³ байна.

2025 онд кемпийн ойр орчимд дэд бүтцийн ажил болон дотоод тээврийн зам тохижуулах ажлын явцад үүссэн нийт 3,000 м³ шимт хөрсийг овоолго үүсгэн хадгалаж нөхөн сэргээлтийн ажилд ашигласан.



Зураг 7. Маркшейдрийн хэмжилтийн үр дүн

Хүснэгт 4- Хөрс, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Д/д	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд тусгасан ажил	Арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлсэн ажил	Тайлбар
1.	Шимт хөрсийг овоолго үүсгэн хадгалах	2025 онд кемпийн ойр орчимд дэд бүтцийн ажил болон дотоод тээврийн зам тохижуулах ажлын явцад үүссэн нийт 3,000 м ³ шимт хөрсийг овоолго үүсгэн хадгалаж нөхөн сэргээлтийн ажилд ашигласан.	Шимт хөрсийг овоолго үүсгэн хадгалаж нөхөн сэргээлтэд ашигласан ажлын зураг


Хэнтий аймгийн Батноров сумын нутагт хэрэгжиж буй “Сэрвэн хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн БОМТ-ний биелэлтийн тайлан-2025 он

		2025 оны 1 га талбайд 30 см-ийн зузаантай шимт хөрс дэвсэж биологийн нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэсэн. Шимт хөрсний овоолгоос дээж авч хөрсний агрохимийн шинжилгээг “Инженер геодези” ХХК-ийн Хөрс судлалын лабораториор хийлгэсэн.	болон хөрсний агрохимийн шинжилгээний үр дүнг доор дэлгэрэнгүй тусгав.
2.	Уурхайн орчны замыг стандартын дагуу тавих, тэмдэгжүүлэх ажил хийх олон салаа зам гаргахаас сэргийлэх	Уурхайн дотоод тээврийн замын хоёр талыг хөмсөгжүүлэн, өмнө жил байрлуулсан замын тэмдгийг засаж сайжруулав.	Зам засварын ажил болон замыг тэмдэгжүүлсэн ажлын зураг хавсаргав.
3.	Барилга байгууламж, ажилчдын хотхоны гадна талбайд ногоон байгууламж бий болгох зорилгоор мод сөөг тарьж ургуулах	2025 оны хавар 5-р сард уурхайн кемпийн ард, харуулын байрны гадна, тэсэлгээний агуулах, нүхэн жорлонгын дэргэд буюу 4 цэгт нийт 500 ширхэг Улиас мод тарьж ургуулсан.	Фото зургаар баталгаажуулав.
4.	Хөрс бохирдуулагч нүхэн жорлонг булж эко 00 байгуулах	Эко нойлын суурийг ухаж бэлтгэсэн 2025 онд багтаан Эко нойлыг ажлыг бүрэн дуусгаж ашиглалтанд оруулна.	Суурийн нүх ухаж бэлтгэсэн ажлын зураг хавсаргав.
5.	Хөрсний бохирдол үүсэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сургалт явуулах	2025 оны 04-р сарын 29-ний өдөр Сэрвэн уурхайн кемпэд ажиллаж байсан нийт 27 ажилчдад “Хөрсний бохирдлоос сэргийлэх, тогтсон маршрутын дагуу үйл ажиллагаа явуулах” чиглэлээр сургалт зохион байгуулсан. Сургалтын агуулга: 1. Хөрс гэж юу вэ? 2. Хөрс үүсэх процесс 3. Хөрсний бүрэлдэхүүн хэсэг 4. Хөрсний бохирдол гэж юу вэ? 5. Хөрс бохирдуулагч хүний үйл ажиллагаа 6. Хөрсний бохирдлын хорт нөлөө 7. Хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх арга зам 8. Дүгнэлт	Сургалтанд хамрагдсан ажилчдын нэрс хавсаргав.
6.	Хөрсний овоолго болон шимт хөрсний овоолгыг УАТ-нд заасны дагуу үүсгэх	Шимт хөрсийг УАТөлөвлөгөөнд тусгасны дагуу овоолго үүсгэн хадгалаж нөхөн сэргээлтийн ажилд ашиглаж байна.	Уулын ажлын дэвсгэр зураг хавсаргав.
7.	Хог хаягдлыг ил задгай шатаахгүй байх,	Батноров сумын Засаг Даргын Тамгын газартай Энгийн хог	

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт хэрэгжиж буй “Сэрвэн хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн БОМТ-ний биелэлтийн тайлан-2025 он

уурхайн кемпийн гадна тохижуулсан хог хаягдал түр хадгалах цэгт байрлуулсан хогийн сав дүүрсэн үед хог хаягдлыг сумын хогийн цэгт хүргэх, фото зургаар баталгаажуулж бүртгэл хөтлөх	хаягдлын гэрээг байгуулан хог хаягдлыг Батноров сумын төвийн хог хаягдлын нэгдсэн цэг рүү тээвэрлэн ажиллаж байна. 2025 онд нийт 3 удаагийн тээвэрлэлтээр сумын нэгдсэн хогийн цэгт 20 тн орчим ахуйн хог хаягдлыг хүргэсэн.	Сумын хогийн цэгт хог тээвэрлэн хүргэсэн ажлын зураг хавсаргав.
---	--	---

2025 оны 04-р сарын 29-ний өдөр “Хөрсний бохирдлоос сэргийлэх, тогтсон маршрутын дагуу үйл ажиллагаа явуулах” чиглэлээр сургалт зохион байгуулсан сургалтад хамрагдсан ажилчдын нэрс.



Зураг 8. Сургалтанд хамрагдсан ажилчдын нэрс

Сургалтын материалын хэсэг

Хүрээлэн буй орчинд хүний үзүүлэх нөлөө

ХӨРСНИЙ БОХИРДОЛ

Боловсруулсан: Г.Бадамгарав

ХӨРСНИЙ БОХИРДОЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Тодорхойлолт:

Хүний үйл ажиллагааны улмаас янз бүрийн химийн бодис, ахуйн болон үйлдвэрийн хаягдал хөрсөнд шингэж ургамал, амьд организмд сөрөг нөлөө үзүүлж хуримтлагдах үзэгдлийг **хөрсний бохирдол** гэнэ.

Мөн түүнчлэн хөрсний бохирдолд байгалийн хүчин зүйл нөлөөлж хөрсний хими, биологийн шинж чанрыг алдагдуулна. Тухайлбал: шар усны үер, байгалийн гамшигт үзэгдлүүд, цаг агаарын өөрчлөлт, үхсэн амьтдын сэг зэм.....



Зураг 9. Сургалтын материалын хэсэг.

2025 оны хавар кемпийн орчимд мод тарьсан ажил.

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт хэрэгжиж буй “Сэрвэн хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн БОМТ-ний биелэлтийн тайлан-2025 он

Кемпийн ард, харуулын байрны гадна, тэсэлгээний агуулах, нүхэн жорлонгын дэргэд нийт 4 цэгт 500 ширхэг Улиас мод тарив.



Зураг 10. Уурхайн кемпээс урагш хөрсний отвалийн урд хэсэгт тарьсан улиас мод



Зураг 11. Нүхэн жорлонгын урд тарьсан модны зураг



Зураг 12. Тэсэлгээний агуулахын дэргэд тарьсан Улиас мод
Хавар тариалсан модны өндөр болон ишний тойргын хэмжилт
Дундаж өндөр- 90 см, ишний бүдүүн- 10 см



2025 онд шинээр үүсгэсэн шимт хөрсний овоолго, нөхөн сэргээлтэд ашиглаж буй ажлын зураг



зураг 13. Шимт хөрсийг овоолго үүсгэж хадгалсан ажлын зураг.



Зураг 14. Овоолго үүсгэсэн шимт хөрсийг нөхөн сэргээлтэд ашиглаж буй ажлын зураг

- ❖ 2025 онд Шимт хөрсний овоолгоос авсан дээжинд хийсэн агорхимийн шинжилгээний үр дүн

2025 оны 09-р сарын 18-ний өдөр шимт хөрсний овоолгоос дээж авч “Инженер геодези” ХХК-ийн Хөрс судлалын лабораториор агрохимийн шинжилгээ хийлгэсэн.

Шинжилгээний үр дүнгээр. Хөрсний pH-8.2 буюу дунд зэргийн шүлтлэг, ялзмагийн агууламж дунд (2.56), давсны агууламж 0.15 % буюу давсгүй, хөрсний шим тэжээлийн элементүүд болох хөдөлгөөнт фосфор 3.7 мг/100 гр буюу дундаас их, хөдөлгөөнт кали 16 мг/100 гр агууламжтай байна.

Хүснэгт 5. Хөрсний шинжилгээний үр дүн

Хөрсний үзүүлэлтүүд	pH	Давс, %	ЦДЧ, dm	Ялзмаг, %	NO ₃ мг/100гр	CaCO ₃ , %	Ca	Mg	Хөдөлгөөнт химийн нэгдэл,	
									P ₂ O ₅	K ₂ O
Шимт хөрсний овоолго	8.2	0.15	0.319	2.56	1.82	0.66	19	12.5	3.7	16

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт хэрэгжиж буй “Сэрвэн хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн БОМТ-ний биелэлтийн тайлан-2025 он

**ХОРС СУДЛАЛЫН
ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**

Дугаар: 25/1517

НИГАХНЕР ГЕОДЕЗИ ХХК
Утас: 77278899, 77283899
E-mail: soil_lab@geo-mongol.mn

Дүгж: авсан огноо: 2025 он 09 сарын 17
Шинжилгээ хийсэн огноо: 2025 он 09 сарын 18-21
Дүгж авсан газрын нэр: Хэнтий аймаг, Батноров сум, МV-010434
Координат: -
Дүгж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: "Биг Моруа Гранд" ХХК
Харилцах утас: 99076529

Хорсны химийн задлан шинжилгээний дүн

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	pH	Дас, %	Цэв, %	Ветис, %	NO ₃ мг/100г	CaCO ₃ , %	Шинжлүүлсэн суурьд ам- жон/100 гр	Шинжлүүлсэн жонжуул- мг/100 гр
0	1	2	3	4	5	6	7	8	10	11	12
1	257447	Хорс-3 ШХО	-	8.18	0.15	0.319	2.56	1.82	0.66	19.0	12.5

Хорсны механик бүрдэлтүүн

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Механик бүрдэлтүүн, %	Шинжлүүлсэн хэмжээ, мм
1	257447	Хорс-3 ШХО	-	24-0.25 0.05 0.01 0.005	0.05 0.01 0.005 0.001

Хорсны хүнд металлы

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Хүнд металлы, мг/кг					
				Ni Никель	Cd Кадмийн	Pb Хар түгэлт	Cu Сү/Хүт	Zn Цайр	Cr Хроми
1	257445	Хорс-1 ДУТ	-	0.64	ND	17.43	7.25	49.44	13.62
2	257446	Хорс-2 ШТС	-	6.13	ND	20.22	8.80	63.29	13.97
Хүндийн агуулга, МНС 5850:2019				150.0	1.0	100.0	100.0	300.0	150.0
Хүндийн агуулга, МНС 5850:2019				1000.0	10.0	500.0	500.0	600.0	400.0
Агуулга, МНС 5850:2019				1800.0	20.0	1200.0	1000.0	1000.0	1500.0
Эхлүүлэгчийн эхлүүлэгчид дээж хийхэд стандарт				МНС 5850:2019					

*ND-not detect

Же: Эхлүүлэгчийн эхлүүлэгчид дээж хийхэд стандартыг биелүүлсэн байгааг нотлох баримт.

Шинжилгээ хийсэн арга стандарт:
(MNS 3310:1991, MNS ISO 10390:2001, MNS 6824:2020, MNS 6988:2022, MNS ISO 11466:2007)

Лабораторийн эрхлэгч: *[Signature]* Л. Цагаансарх /MS c/
Задлан шинжлүүлэгч: *[Signature]* С. Түвшин

Зураг 15. Шинжилгээний бичиг.

2025 онд хийсэн дотоод тээврийн замыг хөмсөгжүүлсэн ажлын зураг, тэмдэгүүдийг сэргээж байршуулав.



Зураг 16. Зам засварын ажлын зураг





Зураг 17. Дотоод тээврийн зам тэмдэгжүүлсэн ажлын зураг

Эко нойлын суурийн байгууламж бэлдсэн байдал



Зураг 18.

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт хэрэгжиж буй “Сэрвэн хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн БОМТ-ний биелэлтийн тайлан-2025 он

Хүснэгт 6- Гадаргын болон газрын гүний усанд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Д/д	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд тусгасан ажил	Арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлсэн ажил	Тайлбар
1.	Тухайн жилийн ус ашиглалтын тайлан мэдээг холбогдох мэргэжлийн байгууллагад хүргүүлэх	2025 онд төслийн “Ус ашиглуулах дүгнэлт”-ийг Монгол Улсын Усны газраар 2025 оны 03-р сарын 27-ны өдөр гаргуулж, дүгнэлтийг үндэслэн 1/74 тоот “Ус ашиглах гэрээ”-г 2025 оны 05-р сарын 28-нд Хэрлэн голын сав газрын захиргаатай байгуулсан. Гэрээнд заасны дагуу 2025 оны ус ашиглалтын тайланг 12-р сарын 30-ны дотор Усны газар болон Сав газрын захиргаанд хүргүүлнэ.	2025 оны устай холбоотой бичиг баримтын бүрдлийг хавсралтаар оруулав.
2.	Шүүрлийн усыг татан зайлуулж хөв цөөрөм байгуулах талаар усны мэргэжлийн байгууллага эсвэл мэргэжилтэнтэй хамтран судалгаа хийх, боломжит нөхцөлийг судлах	Шүүрлийн усаар хөв цөөрөм байгуулах талаар харьяа Хэрлэн голын сав газрын захиргааны мэргэжилтэнтэй уулзаж зөвлөгөө авсан. Мэргэжилтний хэлснээр, уурхайн олборлолт явагдаж буй талбайн газрын өндөршил болон шүүрлийн ус тогтмол соруулалт хийх боломжгүй нөхцөл байдлыг харгалзан үзэхэд тус газарт хөв цөөрөм байгуулах нь техникийн хувьд тохиромжгүй гэж үзэж буйгаа илэрхийлсэн. 2025 онд үйл ажиллагаа явуулсан хугацаандаа уурхай нь зөвхөн 01-р сарын 01-ээс 3 дугаар сарын 25 хүртэлх хугацаанд нийт 2,143 м³ шүүрлийн ус соруулсан бөгөөд бусад саруудад шүүрлийн ус соруулах ажил хийгдээгүй. Иймд дүйцүүлэн Сэрвэн уурхайд ойр байрлах Энгэр булгийн эхийг хашаалах ажлыг 2025 оны Ус ашиглалтын гэрээнд тусгуулсан бөгөөд ажлын даалгавар авах хүсэлтийг	Булгийн хашаалалтын ажлын даалгавар авах хүсэлт болон хашаалах булгийн байршлыг харуулсан зураг хавсаргасан. Тус ажлыг 2025 оны “Ус ашиглах гэрээ” дүгнэхээс өмнө хэрэгжүүлнэ.

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт хэрэгжиж буй “Сэрвэн хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн БОМТ-ний биелэлтийн тайлан-2025 он

		сав газрын захиргаанд хүргүүлсэн.	
--	--	-----------------------------------	--

Булгийн эх хашаалах ажлыг хэрэгжүүлэхээр сав газарт хүргүүлсэн албан хүсэлтийг доор хавсралтаар орууллаа.



“БИГ МОГУЛ ГРАНД” ХХК

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Олимпын гудамж 7/13, Центрум тов,
4 давхар, 401 тоот Утас +976-99090546

И-мэйл: bigmogul.ce@gmail.com

Огноо 2025.10.23 № 25/10/23

Танай _____-ны № _____-т

“ХЭРЛЭН ГОЛЫН САВ
ГАЗРЫН ЗАХИРГАА”-нд

Хүсэлт гаргах нь:

Манай “Биг Могул Гранд” ХХК нь Хэнтий аймгийн Батноров сумын Идэрмэг 5-р багийн нутаг дэвсгэрт орших MV-010434 тоот ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайд уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг.

2025 онд Хэрлэн голын сав газрын захиргаатай байгуулсан №06 дугаартай “Ус ашиглах гэрээ”-ний дагуу Хэрлэн голын сав газарт хамаарах нэг булгийг хашиж хамгаалах ажлыг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн болно.

Иймд дээрх гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор уурхайн орчмын нутаг дэвсгэрт байрлах, хашиж хамгаалах булгийн байршлыг тодорхойлох болон ажлын даалгавар, чиглэл өгөхийг хүсэж байна.

ХҮНДЭТГЭСЭН,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ц.САЙНХҮҮ



Зураг 19. Тус ажлын хүрээнд ашиглалтын талбайгаас баруун хойш 7.8 км зайд орших Энгэр булгийг хашаална.

Хүснэгт 7- Ургамал ба амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Д/д	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд тусгасан ажил	Арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлсэн ажил	Тайлбар
1.	Уурхайн эдэлбэрээс бусад эрүүл талбайд газар ухаж, амьтдын үүр нүх сүйтгэхгүй байх	- 2025 онд ашиглалтын талбайгаас гадна ямар нэг газар шорооны ажил гүйцэтгээгүй. - Мөн тус ажилтай холбоотой “Газар шорооны ажлын үед мөрдөж ажиллах уурхайн дотоод журам”-ыг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна. - 2025 онд уурхайн хог хаягдал түр хадгалах цэгт зөвшөөрөлгүй ухсан нүхийг булж эвдэрсэн газрыг хэлбэршүүлэн, үүссэн хогийн сумын нэгдсэн хогийн цэгт тээвэрлэн хүргэв.	- Баталсан журмыг хавсралтаар оруулав. - Хогийн цэгт зөвшөөрөлгүй ухсан нүхийг булж, хогийн сумын нэгдсэн хогийн цэгт хүргэсэн ажлын зураг хавсаргав.
2.	Хог хаягдлыг ангилан ялгаж, тогтмол хугацаанд зайлуулах, хогийн цэгийг халдваргүйжүүлэх арга хэмжээ авах	Батноров сумын Засаг Даргын Тамгын газартай Энгийн хог хаягдлын гэрээ байгуулан хог хаягдлыг Батноров сумын төвийн хог хаягдлын нэгдсэн цэг рүү тээвэрлэн ажиллаж байна.	Ажлын зураг хавсаргав.

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт хэрэгжиж буй “Сэрвэн хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн БОМТ-ний биелэлтийн тайлан-2025 он

		Уурхайн хогийн цэг нүхэн жорлонд ариутгал халдваргүйжүүлэлтийн ажил тогтмол гүйцэтгэдэг.	
--	--	--	--



Зураг 20. Ариутгалын ажлын зураг

2.2. Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө

Хүснэгт 8- Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилт

Д/д	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд тусгасан ажил	Арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлсэн ажил	Тайлбар
Техникийн нөхөн сэргээлтийн ажил			
1.	Ашиглалт явуулж дууссан талбайд дотоод овоолгоор нөхөн дүүргэлт хийж, хэлбэршүүлэлт, нягтруулалт хийнэ.	Өмнө уурхайн олборлолтын улмаас эвдрэл үүссэн хоёр хэсэг талбайд уулын цулаар дүүргэлт хийж хэлбэршүүлэн техникийн нөхөн сэргээлтийн ажлыг амжилттай хэрэгжүүлсэн. Нийт дүүргэлт хийсэн уулын цулын хэмжээ: 50,315 м³	Нөхөн сэргээлт хийсэн талбайн сансрын зургыг хавсаргав.
2.	Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайг үржил шимт хөрсөөр хучих ажил хийнэ.	Техникийн нөхөн сэргээлт хийсэн 1 га талбайг 0.3 м зузаантай шимт хөрсөөр хучиж биологийн нөхөн сэргээлтийн арга хэмжээг хэрэгжүүлсэн. Ашигласан шимт хөрсний хэмжээ: 3,000 м3	
3.	Ашиглалтын талбайд хуучин үүссэн байсан эвдэрсэн талбайд дүүргэлт хийж хэдбэршүүлэн орон нутагт хүлээлгэж өгөх	2025 онд хуучин эвдрэл үүссэн байсан хоёр хэсэг талбайд нийт 50,315 м³ уулын цулаар дүүргэлт хийсэн.	
Биологийн нөхөн сэргээлтийн ажил			
4.	Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд орон нутгийн онцлогт тохирсон олон наст ургамал тарина.	Техникийн нөхөн сэргээлтийн ажил хийсэн талбайд “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлага” MNS 5918:2008 стандартад заасны дагуу Царгас, Соргүй согоовор, саман ерхөг, ботууль зэрэг 4 төрлийн олон наст ургамлын үрийг хольж тариалан, биологийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэсэн.	Нөхөн сэргээлтийн ажлын дэлгэрэнгүй мэдээллийг доор оруулав.
5.	Уурхайн кемпийн хашаан дотор улиас модыг суулгац (3-4 нас) хооронд 30 см зайтайгаар тарина.	2024 онд кемпийн урд хэсэгт нийт 800 ширхэг улиас модыг суулгацаар тариалсан бөгөөд 2025 онд уурхайн кемпээс урагшаа отвалийн урдуур, халуулын байр, тэсэлгээний агуулах, нүхэн жорлонгын дэргэд нийт 500 ширхэг Улиас мод суулгацаар	Мод тарьсан ажлын зураг хавсаргав.


Хэнтий аймгийн Батноров сумын нутагт хэрэгжиж буй “Сэрвэн хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн БОМТ-ний биелэлтийн тайлан-2025 он

		тариалсан модны ургалт 100 % байна.	
--	--	-------------------------------------	--


2025 оны нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэл

2025 онд ашиглалт явуулж буй талбайд өмнө илээр олборлолт явуулж эвдрэл үүссэн нийт хоёр хэсэг талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэсэн. Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ 0.5 га, Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ 1 га байна.

Нөхөн сэргээлт хийсэн талбайг орон нутагт хүлээлгэж өгөх хүсэлтийг нөхөн сэргээлтийн ажлын тайлангын хамт Хэнтий аймгийн Байгаль орчны газарт 2025 оны 10-р сарын 14-ний өдөр цахимаар хүргүүлэв.



Зураг 21. Нөхөн сэргээлт хийсэн талбай хүлээлгэж өгөх тухай хүсэлт



зураг 22. Нөхөн сэргээлт хийсэн талбайн зураг

Техникийн нөхөн сэргээлт

Техникийн нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд тус талбайд өмнө үйл ажиллагаа явуулж байсан компанийн олборлолтын улмаас эвдрэл үүссэн нийт 0.5 га талбайд нийт 50,321 м³ уулын цулаар дүүргэлт хийж хэлбэршүүлэх ажлыг гүйцэтгэсэн.

Эвдрэл үүссэн талбайд эргэн тойрны хуучин хөрсний овоолго 2025 онд ил аргаар олборлолт явуулах үед үүссэн уулын цул зэргийг ашиглан дүүргэлт хийж, шимт хөрсөөр 0.3 м зузаантай хучсан.

Хүснэгт 9- Нөхөн сэргээлт хийсэн талбайн координат

Цэгийн дугаар	Өргөрөг	Уртраг	Талбайн хэмжээ	Эзлэхүүн/ашигласан уулын цул
Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай			1 га	50,321 м ³
1	47°42'10.78"N	111°35'18.38"E		
2	47°42'12.29"N	111°35'19.38"E		
3	47°42'13.07"N	111°35'19.31"E		
4	47°42'14.49"N	111°35'19.58"E		
5	47°42'14.95"N	111°35'23.25"E		
6	47°42'12.69"N	111°35'21.76"E		
7	47°42'13.19"N	111°35'24.98"E		
8	47°42'10.25"N	111°35'20.99"E		
Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай				
1	47°42'25.48"N	111°35'15.71"E		
2	47°42'26.37"N	111°35'17.22"E		

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт хэрэгжиж буй “Сэрвэн хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн БОМТ-ний биелэлтийн тайлан-2025 он

3	47°42'25.93"N	111°35'18.77"E	0.5 га	
4	47°42'24.74"N	111°35'19.49"E		
5	47°42'23.26"N	111°35'17.78"E		
6	47°42'23.54"N	111°35'16.39"E		



Зураг 23. Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн сансрын зураг, (google earth pro)

Биологийн нөхөн сэргээлт

2024-2025 оны ашиглалтын жилүүдэд дүүргэлт хийж хэлбэршүүлэн шимт хөрсөөр хучиж бэлтгэсэн 1.0 га талбайг ургамалжуулах ажлыг 2025 оны 06-р сарын 19-ний өдөр нийт гурван хүний бүрэлдэхүүнтэй хийж гүйцэтгэв.

2024 онд тус талбайд дүүргэлт хийхэд нийт 50,321 м³ уулын цул ашиглаж, 2025 онд тариалалт хийхэд бэлтгэн 0.3 м зузаантай шимт хөрсөөр жигд хучсан.



Зураг 24. Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайн сансрын зураг

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт хэрэгжиж буй “Сэрвэн хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн БОМТ-ний биелэлтийн тайлан-2025 он

Ажлын үе шат:

- ❖ Талбай бэлтгэх
- ❖ Олон наст ургамлын үрийн судалгаа хийх
- ❖ Үрийн тариалалт

Биологийн нөхөн сэргээлтийн ажилд “Эвдэрсэн газрыг ургамалжуулах MNS 5918:2008 стандартын дагуу Царгас, Соргүй согоовор, Саман ерхөг, Ботууль зэрэг дөрвөн төрлийн бэлчээрийн олон наст ургамлын хольж бэлтгэсэн үрийг холимог бордоотой (NPK) хольж тариалалт хийсэн.

Хүснэгт 10- Нөхөн сэргээлтэд ашигласан ургамлын төрөл

Д/д	Ургамлын нэршил (монгол, латин)	Ургамлын амьдралын хэлбэр	Ургамлын өндөр	Үржлийн хэлбэр	Хэрэглээ
1.	Царгас, <i>Abies sibirica</i> Ledeb.	Буурцагт олон наст	20-30 см	Цэцгээр үржинэ.	Нөхөн сэргээлтэд ашиглана.
2.	Согоовор, <i>Bromus inermis</i> Leyss.	Олон наст үетэн	46-91 см	Цэцгээр болон вегататив үржилтэй.	Нөхөн сэргээлт болон малын тэжээлд ашиглана.
3.	Саман ерхөг, <i>Agropyron cristatum</i> (L.) P. B.	Олон наст үетэн	30-50 см	Цэцгээр үржинэ.	Нөхөн сэргээлт болон малын тэжээлд ашиглана.
4.	Ботууль, <i>Festuca lenensis</i> Drob.	Олон наст үетэн	Иш нь 5-40 см, сахлаг үндэстэй бөгөөд үндэс нь хөрсний гүнд 60-80 см тархана.	Цэцгээр болон вегататив үржилтэй.	Нөхөн сэргээлт болон малын тэжээлд ашиглана.

Үрийн чанарын үзүүлэлт. Үрийн чанарын үндсэн үзүүлэлтүүд болох соёололт, цэвэршилт нь дараах байдалтай байна.

Хүснэгт 3- Нөхөн сэргээлтэд ашигласан үрийн чанарын үзүүлэлт

Д/д	Ургамлын нэр	Соёололт, %	Цэвэршилт, %
1.	Царгас	70	80
2.	Согоовор	75	95
3.	Ерхөг	80	95
4.	Ботууль	65	90

Соёололт (%): Ургамлын үрийн соёололт гэдэг нь тодорхой нөхцөлд (чийг, дулаан, агаар) соёолж, ургах чадвартай үрийн хувь хэмжээг илэрхийлнэ. Соёололт өндөр байх нь нөхөн сэргээлтэд хэрэглэсэн үр илүү үр дүнтэй, үржил шимтэй ургамал болох үндэс суурь болдог.

Цэвэршилт (%): Цэвэршилт гэдэг нь нийлүүлэгдсэн үрэнд хольц (тоос, өвсний үлдэгдэл, хог ургамлын үр зэрэг) ямар хэмжээгээр байгааг илэрхийлэх үзүүлэлт юм. Цэвэршилт өндөр байх тусам тарих үрийн үр ашиг, биологийн нөхөн сэргээлтийн үр дүн сайжирдаг.

Нөхөн сэргээлтэд ашигласан бордоо: Мөн ургамлын үрийн ургалтыг дэмжих зорилгоор

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт хэрэгжиж буй “Сэрвэн хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн БОМТ-ний биелэлтийн тайлан-2025 он

20 кг (**НРК 15-15-15** буюу 15% азот, 15% фосфор, 15% калийн холимог) нийлмэл бордоог үртэй хольж, үржил шимийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.

Хүснэгт 11-Ашигласан бордооны мэдээлэл

Д/д	Элемент	Ургамалд үзүүлэх нөлөө	
1.	Азот (N)	Навч ногооруулах, ургал үе шат хурдасгах	
2.	Фосфор (P)	Үндэс хөгжлийг сайжруулах, бэхжүүлэх	
3.	Кали (K)	Ургамлын эсийн бодисын солилцоог идэвхжүүлэх, хүйтэн ба гангийн эсэргүүцлийг нэмэгдүүлэх	

Биологийн нөхөн сэргээлтэд ашигласан ургамлын үр болон бордоог ургамлын үр, үрсэлгээ худалдаалах үйл ажиллагаа эрхэлдэг олон жилийн туршлагатай “Таримал ургамал” ХХК-аас худалдан авсан.

Нөхөн сэргээлтэд ашигласан техник: Биологийн нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд СПЧ-Сеялка маркийн үрлэгч машин болон МТЗ-80 трактор ашиглан үрийн суулгалт хийсэн. Тариалалтын явцад үрлэх талбайн хэлбэр болон газрын хэвгий зэргийг харгалзан үзэж, дараах байдлаар тариалалтыг гүйцэтгэсэн.

Эхний шатанд талбайн зах хэсгээр бүтэн тойрч хашиж, хүрээлсэн. Үүний дараа газрын байгалийн налуугийн дагуу хөдлөн хөдөлгөөнөөр үр суулгах ажлыг гүйцэтгэсэн.

Тариалалтын ажилд ашигласан техникүүдийг Хэнтий аймгийн Батноров сумын нутагт, Сэрвэн уурхайгаас 17 км зайд орших тариалангийн талбайгаас нэг өдрийн хугацаанд түрээслэн ашигласан болно.

Хүснэгт 12-Биологийн нөхөн сэргээлтийн ажилд ашигласан техник

Д/д	Техникийн нэр	Марк	Тоо ширхэг	Ашигласан техникийн зураг
1.	Үрлэгч машин	СПЧК-6М	1	
2.	Трактор	УТО LX1804	1	

Тариалалт хийсэн хугацаа: Орд газар байрлах талбай нь Монгол орны байгалийн бүс, бүслүүрийн ангиллаар хээрийн бүсэд хамаардаг. Иймд нөхөн сэргээлтийн ургамал тарих хугацааг MNS 5918:2008 “Эвдэрсэн газрыг ургамалжуулах” стандартад заасны дагуу төлөвлөж, хэрэгжүүлсэн.

Усалгаагүй нөхцөлд ургамлын үр тарих тохиромжтой хугацаа нь хээрийн бүсийн хувьд зургаадугаар сарын хоёрдугаар 10 хоног байдаг бөгөөд энэхүү хугацаанд багтаан, 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр биологийн нөхөн сэргээлтийн үрийн тариалалтыг хийж гүйцэтгэсэн.

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт хэрэгжиж буй “Сэрвэн хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн БОМТ-ний биелэлтийн тайлан-2025 он

Хүснэгт 13-Эвдрэл үүссэн талбайг ургамалжуулах хугацаа

Д/д	Байгалийн бүс	Усалгаагүй нөхцөл	Усалгаатай нөхцөл
1.	Уулархаг бүс	06-р сарын 3 дах 10 хоногт	05-р сарын 3 дах 10 хоногт
2.	Ойт хээр, хээрийн бүс	06-р сарын 2 дах 10 хоногт	05-р сарын 2 дах 10 хоногт
3.	Говь цөлийн бүс	05-р сарын 3 дах 10 хоногт	05-р сарын эхний 10 хоногт



Хэнтий аймгийн Батноров сумын нутагт хэрэгжиж буй “Сэрвэн хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн БОМТ-ний биелэлтийн тайлан-2025 он



Хэнтий аймгийн Батноров сумын нутагт хэрэгжиж буй “Сэрвэн хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн БОМТ-ний биелэлтийн тайлан-2025 он

Царгас- дундаж өндөр 80-100 см



Саман ерхөг- дундаж өндөр 35 см



Ботууль- дундаж өндөр 8 см



Зураг 25. Уурхай дээр мод тарьсан ажлын зураг

2.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 14- Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

Д/д	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд тусгасан ажил	Арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлсэн ажил	Тайлбар
1.	Батноров сумын мод үржүүлгийн талбайд нутаг орны байгаль цаг уурт тохирсон мод тарьж сум орон нутагт хүлээлгэн өгөх	2025 онд нийт 200 ширхэг улиас модын сумын засаг даргын тамгын газарт хандивласан.	Орон нутагт мод хүлээлгэн өгсөн ажлын зураг хавсаргав.
2.	Багийн иргэд, нөлөөллийн бүсийн малчин айл өрхийн саналыг харгалзан хөрзөн түрж өгөх	Уурхайн нөлөөллийн бүсэд оршин суугаа нэг айлаас хөрзөн түрж өгөх хүсэлт ирсний дагуу компаний зүгээс шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг гарган ажил гүйцэтгэсэн.	Хүрзэн түрж өгсөн тухай нөлөөллийн бүсийн иргэний баталгаажуулсан албан тоотыг тайлангын ард хавсаргав.

- Орон нутагт мод хүлээлгэж өгсөн ажлын зураг



Зураг 26.

2.4. Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох төлөвлөгөө

Төслийн хүрээнд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа хийгдэхгүй тул БОМТ-нд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй болно.

2.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

2.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 15- Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт

Д/д	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд тусгасан ажил	Хариуцсан албан тушаалтан	Арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлсэн ажил	
1.	Ажилчдад эмнэлгийн анхны тусламж үзүүлэх чадварыг эзэмшүүлэх	Уурхайн эмч	Уурхайд ажиллаж буй ажилчдад эмнэлгийн анхан тусламж үзүүлэх тухай сургалтыг зохион байгуулав.	Ажлын зураг хавсаргав.
2.	Галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар сургалт мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах,	Гэрээт компанийн ХАБЭА хариуцсан ажилтан	Одоогоор тухайн талбайд гэрээт компани үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд манай компанийн зүгээс хяналтын нэг ажилтан байршуулан ажиллаж байна. Иймд 2025 онд манай компаниас мэргэжлийн байгууллагатай хамтран сургалт зохион байгуулах боломжгүй байна. Мөн тус талбайд гэрээгээр үйл ажиллагаа явуулж буй компанийн хувьд өөрийн ажилтнуудаа жил бүр мэргэжлийн байгууллагаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон бусад шаардлагатай сургалтад хамруулах үүрэгтэй болно.	

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт хэрэгжиж буй “Сэрвэн хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн БОМТ-ний биелэлтийн тайлан-2025 он


3.	Уурхайн барилга байгууламж бүрт галын хор байрлуулж хэвийн ажиллагааг тогтмол хянаж бүртгэдэг байх	ХАБЭА хариуцсан ажилтан	Төслийн талбайд барилга байгууламж бүрт галын хор байрлуулж, галын сарааг ШТС, харуулын байр, кемпийн гадна тохижуулсан.	Галын хор байрлуулсан зураг, галын сарааны зураг хавсаргав.
4.	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт жил бүр тогтмол хамруулах. Ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалалтын хэрэгслээр тогтмол хангах, хордлого тайлах хүнс, бэлдмэлээр хангаж байх	Гэрээт компанийн ХАБЭА хариуцсан ажилтан	Тус талбайд гэрээтээр үйл ажиллагаа явуулж буй компани нь өөрийн ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, мөн ажлын хувцас, хамгаалах хэрэгслээр бүрэн хангах үүргийг хариуцна.	
5.	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслээр хангах		Тус талбайд үйл ажиллагаа явуулж буй гэрээт компани нь уурхайд ажиллагсдыг ажлын хувцас, каск, тоосноос хамгаалах маскаар ханган ажиллаж байна.	Ажлын хувцас хэрэгслийн зураг, худалдан авсан баримт хавсаргав.
6.	Ажлын байр, гал тогоонд эмнэлгийн анхан тусламж эмийн сан Байрлуулах	Уурхайн эмч	Эмнэлгийн анхан тусламжын эмийн санг уурхайн ажилчдын гэр кемп, гал тогоо, харуулын байранд байрлуулсан.	Эмийн анхан тусламжын эмийн сангийн зураг хавсаргав.



Зураг 27. Эмнэлгийн анхан тусламжын хайрцаг



Зураг 28. Уурхайн кемпийн гадна, харуулын байр, ШТС-ын дэргэд байрлуулсан галын сараа.



Зураг 29. Гэр кемпүүд болон гал тогоонд байруулсан галын хор

Уурхайн ажилчдын хамгаалах хуцас хэрэгсэл худалдан авсан баримт, ажлын хувцас хэрэгслийн зураг



Хэнтий аймгийн Батноров сумын нутагт хэрэгжиж буй “Сэрвэн хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн БОМТ-ний биелэлтийн тайлан-2025 он

НХМаягт БМ-3

Сэлэнгэ аймгийн 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралт

ЗАРЛАГЫН БАРИМТ № 57124825

(Байгууллагын нэр) (Худалдан авагчийн нэр)

Регистрийн № _____ Регистрийн № _____

2025 оны 3 сарын 7 өдөр (тээвэрлэгчийн хаяг, албан тушаал, нэр)

№	Материал үнэт зүйлийн нэр, зэрэг, дугаар	Код	Хэмжээ, нэгж	Худалдах	
				Тоо	Нийт дүн
1	А 4/6/4/4	61	15	8800	132000
2	Турим	61	15	15800	237000
3	8/8/8	61	15	5200	78000
4	8/8/8	61	15	4500	67500
5	8/8/8	61	15	880	13200
6	8/8/8	61	15	880	13200
7	8/8/8	61	15	880	13200
8	8/8/8	61	15	880	13200
9	8/8/8	61	15	880	13200
10	8/8/8	61	15	880	13200
11	8/8/8	61	15	880	13200
12	8/8/8	61	15	880	13200
13	8/8/8	61	15	880	13200
14	8/8/8	61	15	880	13200
15	8/8/8	61	15	880	13200
16	8/8/8	61	15	880	13200
17	8/8/8	61	15	880	13200
18	8/8/8	61	15	880	13200
19	8/8/8	61	15	880	13200
20	8/8/8	61	15	880	13200

Тэмдэгт Хүлээн авсан: Шалгасан нягтлан бодогч:

НЭХЭМЖЛЭХ №

Нэхэмжлэгч: Байгууллагын нэр: БМЗ

Хаяг: ТБАН 77000500

Утас: Факс:

Э. шуудан: Хаяг: Гэрээний №

Банкны нэр: Хаяг Банк

Банкны дансны дугаар: 5007598788

Регистрийн №: Төлбөр хийх хугацаа: 2025.09.22

№	Гүйлгээний утга	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Хүлээн авсан	1	140,000	140,000
2	Турим	1	160,000	160,000
3	Хаяг	1	30,000	30,000

Мөнгөний дүн: 330,000

Дарга: Хүлээн авсан: Нягтлан бодогч:

2.7. Хог хаягдлын менежмент

Хүснэгт 16- Хог хаягдлын менежментийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Д/д	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд тусгасан ажил	Арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлсэн ажил	Тайлбар
1.	Төслийн талбайд үүссэн бүх хатуу хог хаягдлыг цуглуулж сумын хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэх	Батноров сумын Засаг даргын Тамгын газартай энгийн хог хаягдлын үйлчилгээний гэрээ байгуулан, уурхай дээрээс гарах хог хаягдлыг Батноров сумын төвийн хог хаягдлын нэгдсэн цэг рүү тогтмол тээвэрлэн ажиллаж байна. 2025 оны 3, 6, 10-р саруудад нийт 3 удаагийн тээвэрлэлтийг зохион байгуулж, тухайн онд ойролцоогоор 20 тн орчим ахуйн хог хаягдлыг сумын нэгдсэн хогийн цэгт тээвэрлэн хүргэсэн болно. Мөн “Хог хаягдлыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах үйл ажиллагаанд мөрдөх уурхайн дотоод журам”-ыг боловсруулан	Хог хаягдлын гэрээ, Хог хаягдлын дотоод журам хавсаргав.

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт хэрэгжиж буй “Сэрвэн хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн БОМТ-ний биелэлтийн тайлан-2025 он

		баталж, үйл ажиллагаандаа тогтмол хэрэгжүүлж байна.	
2.	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах тухай нийт ажилчдад сургалт орох	Уурхайн нийт ажилчдад хог хаягдлын зөв зохистой менежмент сэдвээр 2025 оны 04-р сарын 03-ний өдөр зохион байгуулсан.	Сургалтын явцын зураг, сургалтанд хамрагдсан ажилчдын гарын үсэг хавсаргав.
3.	Хог хаягдал түр хадгалах цэгийн талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулах	2025 онд үйл ажиллагааны догогдолоос шалтгаалан тус ажлыг хэрэгжүүлэхэд хүндрэл учирсан иймд 2026 оны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.	-
4.	Бохир ус цугларуулах цооногийг бохир ус хөрсөнд нэвчихээргүй байдлаар шийдэх, Ахуйн бохир ус соруулах гэрээг мэргэжлийн байгууллагатай байгуулах	Уурхайн ариун цэврийн байгууламжыг бохир ус хөрсөнд нэвчихээргүй болгон суурийн байгууламжыг бэлтгэсэн. Хэнтий-Ус ХХК-тай бохир ус соруулах гэрээ байгуулах хүсэлт илгээсэн байна.	-
